



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/135

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, дүүргийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/132 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 28-ны өдрүүдэд дүүрэгт орсон борооны улмаас Биеийн тамир, спортын хорооны дээврээс ус гоожиж байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан тул дээврийн хэсэгчилсэн засварын ажлыг гүйцэтгэсүгэй.

2.Засварын ажилд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3.Дээврийн засварт шаардагдах 1,805,000 (нэг сая найман зуун таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Тус ажлыг зохион байгуулж дууссанаас хойш 14 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 07 сарын 29-ны өдрийн А/БС дугаар
захирамжийн хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДЭЭВРИЙН ЗАСВАРТ
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Чулуугүй цаас наадаг	боодол	7	76,000	532,000
2	Чулуутай хар цаас	боодол	7	96,000	672,000
3	Битум	ш	2	56,000	112,000
4	Цемент	ш	9	23,000	207,000
5	Элс, хайрга	т	1	157,000	157,000
6	Хар тос	кг	25	5,000	125,000
Нийт дүн:					1,805,000